

**Төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээс  
чухал ажил төрийн албан хаагчдад байхгүй**

*/Аргачилсан зөвлөмж/*

Хяналт шинжилгээ үнэлгээний тасаг төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэхдээ “Бодлогын баримт бичиг”, “Холбогдох эрх зүйн акт”-ын хэрэгжилтийн байдлыг түлхүү харгалздаг.

Эдгээрийг “Захиргааны байгууллагын хяналт шинжилгээний журамд:

5.1. *“Бодлогын баримт бичиг” гэдэгт Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, үндэсний хөтөлбөр, төсөл, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, аймаг, сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг баримт бичгийг;*

5.2. *“Холбогдох эрх зүйн акт” гэж тухайн салбар болон байгууллагын эрхлэх асуудал, эрх хэмжээний хүрээний асуудлаар үүрэг, даалгавар, чиглэл өгсөн Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, аймгийн ИТХ-ын тогтоол, Засаг даргын албан даалгавар болон захирамжийг; хамааруулан ойлгохоор заасан байна.*

Тэгэхлээр эдгээр бодлого, шийдвэрийн хэрэгжилтийн байдлаас сум, агентлагийн үйл ажиллагааны үр дүн шууд хамаарч байгаа юм.

Хяналт шинжилгээний үнэлгээний тасгаас сум, агентлагт хийсэн хяналт шалгалтын байдлаас үзэхэд “Захиргааны байгууллагын хяналт шинжилгээний журам” хэрэгжүүлэхэд хангалтгүй анхаарч байгаа дутагдал байна.

Үүнийг хэт ерөнхий дүгнэлт гэж ойлгож магадгүй.

Товчоор илэрхийлбэл, төрийн албан хаагчдад төрийн бодлого, шийдвэрийг ингэж хэрэгжүүлж байна гээд үзүүлэх баримт материал байхгүй байгаагаас л ийм дүгнэлтэд хүрч байна.

**-Таны эрхэлсэн асуудлын хүрээнд Засгийн газрын хэдэн тогтоол, аймгийн Засаг даргын хэдэн захирамжийн хэдэн заалт байна, хэрэгжилт нь хэдэн хувь байна?** гэхэд яаг таг хариулах хүн хэд байгаа билээ.

***-“Шинэ Булган” хөтөлбөрийг хэрэгжүүлэх хэдэн арга хэмжээ хамааралтай билээ. Дэвшүүлсэн зорилт, шалгуур үзүүлэлтийг ямар түвшинд хангаж байгаа бол?*** гэдэгт хариулт өгдөг байх нь төрийн албан хаагчдад тавих шаардлага.

Тиймээс энэ аргачилсан зөвлөмжийг манай тасгаас хүргүүлж байна.

- **“Хариуцлага тооцох механизм бүрдүүлэх”**

Төрийн албаны удирдах албан тушаалтнуудад төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг сайжруулахад чиглэсэн эрх зүйн зохицуулалт хангалттай байна. Түүнийг бүрэн ашиглаж чадахгүй, ажлыг урсгалаар явуулж хэвшил тогтоосноор төрийн бодлого, шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь харагдаж байна. Зарим газар төрийн албан хаагчид төрийн бодлого шийдвэрийг хангалтгүй хэрэгжүүлсэн байна гээд арга хэмжээ авах боломжгүй болтлоо ажил нь унасан гэж харагдахаар байлаа. Энэ нь “Тухайн төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод энэ талаар тусгаагүй орхигдуулсан” гэсэн үг. Ажлын байрны зорилт, чиг үүрэгт заагаагүй ажлыг гүйцэтгүүлж, арга хэмжээ авсан нөхцөлд удирдах ажилтан өөрөө буруутгагдах нөхцөл болно.

Тиймээс ***Хэн ямар ажлыг, ямар аргаар, хэрхэн гүйцэтгэж, юу бүтээж байгааг тооцоход анхаармаар байгаа юм.***

Үүний тулд

- **Ажлын байрны тодорхойлолтод заах**

Төрийн албаны тухай хуулийн 11.1 ***“Төрийн албан тушаал эрхэлж, бүрэн эрхээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл, баталгаагаар хангагдан ажиллаж байгаа этгээдийг төрийн албан хаагч гэнэ”*** гэж заасан.

Төрийн албан хаагчийн албан тушаалын бүрэн эрхэд төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажил зайлшгүй байна.

Монгол улсын Засгийн газрын “Засгийн газрын тогтоол /захирамж/, хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх ажилтай холбогдсон зарим арга хэмжээний тухай” 1996 оны 66 дугаар тогтоолд:

***“Нэг.Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдээлэх, нийтэд сурталчлахтай холбогдсон үүргийг төрийн албан хаагч бүрийн ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарьт тодорхой тусган биелэлтийн байдлыг улирал бүр дүгнэж ажиллахыг төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад даалгасугай”*** гэж заажээ. /Монгол улсын Засгийн газрын

2013 оны 322 дугаар тогтоолоор “улирал тутам” биш “хагас жилд” биелэлтийг нь тооцож байхаар болсон.

Энэ шийдвэрийг баримтлан:

- **Эрх зүйн актын хэрэгжилтийг зохион байгуулах**
- **Үр дүнг тооцох**
- **Мэдээлэх**
- **Нийтэд сурталчлах** гэсэн чиг үүргийг ажлын байрны тодорхойлолтод

зааж оруулах нь зүйтэй.

Нөгөө талаар *Засгийн газар, аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх* үүргийг бас тусгах хэрэгтэй.

- **Үйл ажиллагааны төлөвлөгөөнд оруулах**

Нэгэнт төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод дээрх ажлыг заасан учраас байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлтөд зайлшгүй тусгагдах ёстой. Ажлын байрны тодорхойлолт гэдэг тухайн байгууллагын орон тоог илэрхийлэх нэг хэлбэр учир тухайн хүний ажил үүрэг байгууллагын үйл ажиллагаатай холбоотой байдгаас төлөвлөлтөд нөлөөлөхөөс өөр аргагүй.

- **Шалгуур үзүүлэлт зааж байгууллагын төлөвлөгөөнд тусгах**

Тухайлбал үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой арга хэмжээг тусгажээ гэж бодоход бодлогын зорилтын хэрэгжилтийн хүрэх түвшинг зааж өгнө гэсэн үг.

“Шинэ Булган” хөтөлбөрийн 53 дахь зорилтын хүрэх үр дүн “Сумын номын сангийн байнгын уншигчдыг 20.0, нүүдлийн номын сангаар үйлчлүүлэгчдийг 30.0 хувьд хүргэх” гэж тодорхойлсон. Энэ зорилтын биелэлт тухайн жил ямар түвшинд хүрэх вэ гэдгийг зааж үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах нь зүйтэй.

- **Үр дүнгийн гэрээнд тусгах**

Төрийн албан хаагчийн ажлын байрны тодорхойлолтод төрийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх талаар тусгасан учраас үр дүнгийн гэрээнд нарийвчлан оруулж өгөх шаардлагатай. Тэгэхдээ тусгай захиалгат ажил үйлчилгээ байхаар сонгох нь зүйтэй байх.

Арга зам нь:

- **Бодлогын зорилт, хөтөлбөрийн заалтыг оруулах**

- **Тогтоол шийдвэрийн заалтыг заах /зарим заалтыг тэр чигээр нь авсан ч болох талтай/**
- **Бодлогын зорилтын хангалтгүй хэрэгжиж байгаа арга хэмжээг тусгайлан авч үзэх** гэх мэт хэлбэрээр үр дүнгийн гэрээнд тусгаж болох юм.

- **Эцсийн үр дүнгээр нь хариуцлага тооцох**

Гэрээнд заасан ажил үйлчилгээний үр дүнг бодитойгоор тооцоход анхаарна гэсэн үг. Нэгэнт тухайн төрийн албан хаагчийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичигт бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн актын хэрэгжүүлэх талаар тусгасан учир шагнах, арга хэмжээ тооцох боломжтой гэж үзэж болно.

**Бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн актыг хэрэгжүүлэхэд хэн юу хийх вэ?**

Хяналт шинжилгээ үнэлгээний тасгаас хийсэн шалгалтаар зөвхөн мэдээлэл өгөх байдлаар Бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн актыг хэрэгжүүлж байгаа байдал харагдаад байдаг. Хагас жил болохоор биелэлтийг нь гаргаж өгчихөөд суугаад байх жишээтэй. Тогтоол шийдвэрийн хувийн хэрэг байна уу гэхээр зарим хүнд алга байдаг. Комьютерт байгаа гэж хэлнэ. Зарим нь комьютерээ “форматалсан” гэдэг.

Ийм байдалд хүрэхгүйн тулд хэн яг юу хийх ёстой вэ?

**Мэргэжилтэн**

- Холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийг судлан өөрийн харьяалах салбар, чиглэлийн **шийдвэрийг хяналтад авах**
- Холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн заалт бүрийг хэрэгжүүлэх талаар **хагас жил, жилийн төлөвлөгөө** гаргаж **батлуулсан** байх
- Холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх ажил зохион байгуулах, **долоо хоног, сар, улирлын төлөвлөгөөнд** тусгаж шийдвэрлэх
- Холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн заалт бүрийн хэрэгжилтийг **хүрсэн үр дүн, үр нөлөөг** тодорхой харуулахаар дүгнэлттэй биелэлтийг тооцож мэдээлэх

Биелэлтийн мэдээллийг гаргахдаа **“Асуултад хариулах замаар тайлагнах”** нь оновчтой арга. Зарим газраас агуулгын хувьд шаардлага хангахгүй мэдээлэл ирүүлдэг учраас анхааруулж байгаа юм.

Энд жишээ татъя. Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт **“Аймгуудын захуудыг эрүүл ахуйн хангасан бизнесийн жишигт нийцсэн**

**худалдааны төв болгох”** зорилтын **“Хүнсний захуудын мал эмнэлэг, ариун цэвэр магадлан шинжилгээний лабораториудын чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх”** гэсэн арга хэмжээ бий.

**Хэрэгжилт нь:** Бизнесийн жишигт нийцсэн худалдааны төвийн барих ажлын хүрээнд нийт 1,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл боловсруулан зураг төсөл нь хийгдэж, хэрэгжүүлэн ажиллах хувийн хэвшлийн саналыг хүлээж байна. Аймгийн төвд эрүүл ахуйн шаардлага хангасан нийтийн бие засах газар 2 барьж ашиглалтанд орсон. ЖДҮД сангаас Баян-Агт сумын “Наран–уул” аж ахуйн нэгжид Хануй голын рашаан сувилалын газарт био жорлон барих төсөлд 47,8 сая төгрөгийн зээл олгосон байна” гэсэн байна.

Хэрэгжүүлэх арга хэмжээнээс биелэлт нь агуулгын хувьд мэдээж зөрөөтэй харагдаж байна.

**“Асуултад хариулах замаар биелэлтийн мэдээллийг тайлагнах”** гэдгийг дараах байдлаар ойлгоход буруудахгүй байх.

- **Эрүүл ахуйн хангасан худалдааны төв байна уу?**
- **Бизнесийн жишигт нийцсэн худалдааны төв байгаа юу?**
- **Хүнсний зах хэд билээ?**
- **Хүнсний захын мал эмнэлэг, ариун цэврийн хяналт ямар байдаг вэ?**
- **Магадлан шинжилгээний лаборторитой эсэх?**
- **Лаборторийн хүчин чадал, шинжилгээ хийх боломж юу билээ?**
- **Ариун цэврийн хяналтыг сайжруулах ямар дэмжлэг үзүүлэв?**

гэдэг асуулт тавьж хариулах замаар биелэлтээ тооцно гэсэн санаа. Хэрэв ингэж ойлгож тайлагнасан бол “ариун цэврийн өрөө, бие засах газрын тухай” бичихгүй л байсан байх.

Холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийг хэрэгжилтийг тооцож мэдээлэхдээ “Орон нутгийн захиргааны байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээний журам”-д заасан **стандартын** дагуу гаргасан байх /Үүнийг аймгийн Засаг даргын 2013 оны А/477 дугаар захирамжийг уншиж танилцаарай./

#### **Дарга, төрийн захиргааны асуудал хариуцсан мэргэжилтэн**

- Шинээр гарсан холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийг ажилтнууддаа тухай бүр **танилцуулах**

- Холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн заалтыг **ажлын байрны тодорхойлолт, хариуцсан ажлын чиг үүргийг** харгалзан мэргэжилтнүүдэд хариуцуулан **хяналтад авах**
- Холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн заалт бүрийг хэрэгжүүлэх ажлын **төлөвлөгөөг батлах**
- Холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх ажлыг **удирдлага, зохион байгуулалтаар** хангах
- Холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн хэрэгжилттэй танилцаж **зөвлөмж, чиглэл, үүрэг даалгавар** өгсөн байх
- Нэг шийдвэрийн болон нэг заалтыг холбогдох байгууллагууд **хамтран** хэрэгжүүлэхээр бол мэргэжилтэн бүрт тус тусад нь хариуцуулж хэрэгжилтийг тооцож, **нэгтгэх**

*Тухайлбал аймгийн Засаг даргын “Шинэ Булган” хөтөлбөрийн 32 дахь зорилтын 4 дэх арга хэмжээ болох “Хүн малын бруцеллёз өвчнийг эрт илрүүлж, хөдөөгийн багийн иргэдийг үзлэг шинжилгээнд бүрэн хамруулан, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг орон нутгийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулах” гэж заасан. Үүний хэрэгжилтийг суманд эрүүл мэндийн төв, мал эмнэлэг үржлийн тасаг хамтран хариуцах учиртай. Тэдгээр байгууллагын гаргасан тайланг Тамгын газар нэгтгэн дүгнэж биелэлтийг тооцно гэж ойлгож хэрэгтэй.*

- Аймгийн Засаг даргын Захирамжаар батлагдсан **хугацааны** дагуу холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг **мэргэжилтэн бүр дээр тооцож** байх

*Аймгийн Засаг даргын 2015 оны А/118 дугаар захирамжаар батлагдсан “Хугацаатай мэдээ тайлангийн хуваарийг баримтлан сумандаа тайлан мэдээгээ авах хуваарь гаргаж баталгаажуулах хэрэгтэй. Зарим суманд мэдээ тайлангийн хуваарийг албажуулан батлаагүйгээс хэн хэзээ ямар мэдээлэл өгөх, эсэх нь тодорхойгүй байдал ажиглагдаж байсан юм.*

- Холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцыг Засаг даргын зөвлөлд **танилцуулж**, өгсөн чиглэл, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажил **зохион байгуулах**

*Энэ нь “Захиргааны байгууллагын хяналт шинжилгээний журам”-д заасан гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх ажил юм. Ямар эрх*

зүйн актын хэргэжилт хангалтгүй байна. Үйл ажиллагааны хөтөлбөрөөс ямар арга хэмжээ удаашралтай байгааг зааж хэрэгжүүлэх ажил зохион байгуулах хэрэгтэй юм.

### **Хариуцлага**

- Мэдээлэгдсэн асуудлын **эцсийн хариуцлагыг** мэргэжилтэн хүлээнэ. Ийм хариуцлага байхгүйгээс тухайн хүн цаг хугацаанд шахагдаад “тайлан мэдээ” өгсөн болоод өнгөрдөг. Эцсийн хариуцлага нь анх мэдээлэл гаргасан хүний толгой дээр буудаг бол арай ч инээдтэй зүйл бичээд байхгүй. “Шинэ Булган” хөтөлбөрийн биелэлтийн тайланд:

*/2013-2014 оны өвөл хаварт малчдад 20 тонн өвс, 16 тонн тэжээлийг малчдад хөнгөлөлттэй үнээр олгож, 20 тэжээл нэмж аван нөөцийн бүрдүүлэлт хийсэн байна. 2014-2015 оны хичээлийн жилд 4750 тн байгалийн хадлан, 16.8 тн тэжээл бэлтгээд байна/,*

*Мал амьтны халдварт, паразиттах халдваргүй өвчний онош тогтоох тандах, зарим халдварт өвчнөөс эрүүлжүүлэх халдварлалтын хувийг **бууруулах арга хэмжээг** зохион байгуулж, 1324 хуц ухнаас цусны дээж авч шинжлүүлж, паразиттах өвчний тандалт судалгаа явуулж **үхрийн гууртах явдал ихэссэн байна/** гэх мэтийн наад захын баримт жишээ олон байна.*

- Холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг зохион байгуулах, төлөвлөх, мэдээлэх, сурталчлах талаар **хариуцлагагүй хандсан** мэргэжилтнүүдэд арга хэмжээ авч болно. Тухайн төрийн албан хаагч ажлаа хэрхэн чанартай гүйцэтгэж байгааг харуулах чанарын үзүүлэлт юм.
- Холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийг **хугацаанд нь ирүүлээгүй** мэргэжилтнүүдэд хариуцлага тооцох боломж бий. Энэ нь харин тооны үзүүлэлт болж үнэлэгдэнэ.
- Холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ аваагүй, хэрэгжилт хангалтгүй байгаа **салбарын үнэлгээг** харгалзан дарга, мэргэжилтэн нарт хариуцлага тооцож байх нь зүйтэй.
- Холбогдох эрх зүйн акт, бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжилтийг тооцож мэдээлэх, хэрэгжилтийн үр дүнгээр

хариуцлага тооцохдоо **локаль** хэм хэмжээ буюу “Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журам” болон тусгайлсан журам гарган баримталж болно.

Нэгэнт ажлын байрны тодорхойлолт, үр дүнгийн гэрээнд заасан ажил үүргийн хэрэгжилтээр хариуцлага тооцох механизм үйлчлэх болохоор аль аль талдаа маргаан гарах магадлал бага байна.

## **ХЯНАЛТ ШИЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ**



### **ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ (ЗАХИРАМЖ) ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ**

1996 оны 3 дугаар сарын 20-ны өдөр

Улаанбаатар хот

#### **Дугаар 66**

#### **Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:**

Нэг.Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, мэдээлэх, нийтэд сурталчлахтай холбогдсон үүргийг төрийн албан хаагч бүрийн ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарьт тодорхой тусган биелэлтийн байдлыг улирал бүр дүгнэж ажиллахыг төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын удирдлагад даалгасугай.

Хоёр.Монгол Улсын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахтай холбогдуулан дор дурдсан журам тогтоож мөрдүүлсүгэй:

#### **1.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар:**

а/хууль тогтоомж бүрт (түүний албан ёсны эх хувийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор) нь хувийн хэрэг нээж, хэрэгжилтийг хангуулах талаар тодорхой



хариуцах эзэн, хугацаатай төлөвлөгөөг холбогдох яам, газруудтай хамтран гаргаж, биелэлтийг дүгнэн хувийн хэрэгт баяжилт хийж байх;

б/хууль тогтоомжийг мэдээллийн санд оруулж, шаардлагатай мэдээллийг яам, Засгийн газрын үндсэн болон дэд бүтцийн газар (цаашид яам, тусгай газар гэнэ), аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон холбогдох бусад байгууллагад хүргүүлж байх;

в/хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон Засгийн газар, яам, тусгай газар болон нутгийн захиргааны байгууллагаас гаргах дүрэм, журам, заавар, жагсаалт зэрэг эрх зүйн бусад баримт бичгүүдийг цаг хугацаанд нь батлуулан мөрдүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавих;

г/дангаараа болон холбогдох байгууллагатай хамтран хууль тогтоомжийн хэрэгжилтийг яам, тусгай газар, аймаг, нийслэлд шалгаж, шаардлагатай тохиолдолд авах арга хэмжээний талаар санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулан шийдвэрлүүлж байх.

## **2.Хууль зүйн яам:**

а/хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид эрх зүйн бусад актыг нийцүүлэх ажлыг холбогдох яам, тусгай газартай хамтран зохион байгуулж, санал боловсруулан Засгийн газарт оруулан шийдвэрлүүлж байх;

б/хуулийг тайлбарласан лекц, ярианы сэдвийг холбогдох яам, тусгай газартай хамтран боловсруулах ажлыг (хууль батлагдсанаас хойш нэг сарын дотор) зохион байгуулах;

в/хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, сурталчлан таниулах, сургалт явуулах талаар аймаг, нийслэлийн Засаг дарга нарт аргачилсан удирдамж, чиглэл гарган хүргүүлж, биелэлтийг нэгтгэх;

г/хуулийг Монгол Улсын хууль тогтоомжийн бүртгэл, лавламжийн санд авч, компьютерийн мэдээллийн баазад оруулан холбогдох нэмэлт, өөрчлөлтийг тогтмол хийж, иргэд, байгууллагад мэдээллээр үйлчлэх;

д/хуулийг хэрэгжүүлэх явцад бусад хууль тогтоомжтой зөрчилдсөн, нэгдсэн ойлголт тогтоох шаардлагатай болсон асуудлыг нэгтгэн судалж, зөрчлийг арилгуулах, албан ёсны тайлбар гаргуулах арга хэмжээ авах;

е/хуулийн талаар радио, телевиз болон хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр хийх сурталчилгааг хууль хяналтын бусад байгууллагатай хамтран зохион байгуулах;

ж/хуулийн хэрэгжилтийн байдлыг холбогдох яам, тусгай газартай хамтран судалж, цаашид боловсронгуй болгох арга хэмжээг зохион байгуулах.

### **3.Яам, тусгай газрууд:**

а/хууль тогтоомжийг салбарын хууль тогтоомжийн санд оруулж, эрхэлсэн хүрээний асуудалд хамаарах заалт бүрт хувийн хэрэг нээн түүнийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажлыг тусган баяжуулалт хийж байх;

б/хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар дор дурдсан асуудлыг тусгасан ажлын төлөвлөгөө боловсруулан баталж (шаардлагатай бол Засгийн газарт оруулан батлуулж) хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах:

-хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг тооцож, зохих журмаар шийдвэрлэх;

-хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага, ажилтны үйл ажиллагааг хооронд нь уялдуулах, шаардлагатай бол орон тоо, бүтэц зохион байгуулалтдаа зохицуулалт хийх арга хэмжээ авч түүний аргачлал, удирдамжийг салбарын болон нутгийн захиргааны байгууллагад хүргүүлэн биелэлтийг хангуулах;

-хуульд заасны дагуу шаардлагатай журам, дүрэм, заавар, жагсаалт зэрэг эрх зүйн бусад баримт бичгийг боловсруулан мөрдүүлэх;

-мөрдөж буй журам, тогтоол шийдвэрийг хуульд нийцүүлэн өөрчлөх, хүчингүй болгох санал боловсруулах;

-Хууль зүйн яамтай хамтран хуулийн талаар лекц, ярианы сэдэв боловсруулж, радио, телевиз, хэвлэлээр болон бусад хэлбэрээр нийтэд сурталчлах, орон нутагт хүргэх ажлыг зохион байгуулж үр дүнг нэгтгэн тооцож байх;

-хуулийг хэрэгжүүлэх боловсон хүчнийг бэлтгэх, нэгдсэн семинар, сургалт зохион байгуулах.

в/хуулийн хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хууль тогтоомжийг цаашид боловсронгуй болгох талаар санал боловсруулж Засгийн газарт оруулах;

г/хуулийг хэрэгжүүлэх явцад илэрсэн зөрчил дутагдлын талаархи дүн мэдээг жил бүрийн 1 дүгээр сарын 5-ны дотор гарган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байх.

### **4.Аймаг, нийслэлийн Засаг дарга нар:**

а/хууль тогтоомжийг хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн аймгийн санд авч, сум, дүүргийг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомжоор аймаг, нийслэлийн

Засаг дарга, тэдгээрийн Тамгын газарт хариуцуулсан үүргийн талаар тус бүрт нь хувийн хэрэг нээж, хэрэгжүүлэх талаар зохиосон ажлаа тусган баяжуулах ажлыг зохион байгуулах;

б/хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ болон хөрөнгийн эх үүсвэр, шууд хариуцан гүйцэтгэх байгууллага, албан тушаалтныг тодорхойлсон төлөвлөгөө, удирдамжийг Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэж нийт сум, дүүрэгт хүргүүлэн биелэлтийг хангуулах;

в/хууль тогтоомжийг хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтнуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, тэдгээрт тусгайлан сургалт, семинар зохион байгуулах;

г/хууль тогтоомжийг орон нутгийн бүх төрлийн мэдээллийн хэрэгслээр сурталчлан тайлбарлах, аж ахуйн нэгж, байгууллагад сэдэвчилсэн семинар, ярилцлага зохиох зэрэг тодорхой үйл ажиллагааг хариуцах эзэн, хугацаа, хөрөнгийн эх үүсвэрийн асуудлын хамт нарийвчлан тусгасан тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, дүнг хагас жил тутамд Хууль зүйн яаманд ирүүлж байх;

д/хуулийн заалтад урьд гаргасан захирамж, бусад шийдвэрүүдийг нийцүүлэн өөрчлөх, нэмэлт тодотгол оруулах арга хэмжээ авч, сум, дүүргийн Засаг дарга нарын шийдвэрийг хуульд нийцүүлэх ажлыг зохион явуулж байх;

е/хууль тогтоомжийн биелэлтийг бүрэн эрхийнхээ хүрээнд шалгаж илэрсэн зөрчлийг арилгуулах, шаардлагатай бол хуулийг боловсронгуй болгох асуудлыг судлан, саналаа холбогдох яам, тусгай газартай хамтран боловсруулж Засгийн газарт танилцуулах;

ж/хуулийг хэрэгжүүлэх явцад илэрсэн зөрчил дутагдлын талаархи дүн мэдээг жил бүрийн 1 дүгээр сарын 5-ны дотор гарган Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлж байх.

#### **5.Сум, дүүргийн Засаг дарга нар:**

а/зохиох төлөвлөгөө, удирдамжийн дагуу нийт баг, хороодын Засаг дарга нарыг хууль хэрэгжүүлэх, түүнийг нийтэд сурталчлах ажлын арга зүйн удирдлагаар хангаж, уг арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд зохион байгуулах;

б/бүрэн эрхийнхээ хүрээнд хуулийн биелэлтийг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллага, харьяалах нутаг дэвсгэртээ шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

в/хуулиар хүлээлгэсэн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

г/хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдсон мэдээлэл, судалгааг тогтоосон журмын дагуу гаргах.

б.Баг, хорооны Засаг дарга нар:

а/зохих төлөвлөгөө, удирдамжийн дагуу дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хуулийг сурталчлах ажлыг зохион байгуулж, энэ ажилд хуульчид, мэргэжлийн хүмүүсийг оролцуулах;

б/хуулиар шууд хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах;

в/хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн эрхийнхээ хүрээнд шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах.

Гурав.Яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хуулийн зөвлөх, мэргэжилтнүүдэд зориулан эрх зүйн сургалт, семинарыг Хууль зүйн яамнаас холбогдох яам, тусгай газар болон аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран зохион явуулж байх, семинарт оролцогчдын унаа, байр, томилолтын зардлыг харъяалах үндсэн байгууллагууд, бусад зардлыг зохион байгуулж байгаа байгууллага хариуцан гаргаж байхаар тогтоосугай.

Дөрөв.Энэ тогтоолын хэрэгжилтийг жил бүр дүгнэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (С.БАНЗРАГЧ)-т даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П.ЖАСРАЙ

Хууль зүйн сайд

Н.ЛУВСАНЖАВ

## **Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ үнэлгээний тасаг**



Mass mail

[Batjrgl\\_miee@yahoo.com](mailto:Batjrgl_miee@yahoo.com)

[Sh\\_bldbaatar@yahoo.com](mailto:Sh_bldbaatar@yahoo.com)



Social  
Network



Batjrgl miee



Boldbaatar sharavjamts



ЛАВЛАХ УТАС

7034-3426

**Булган аймгийн Засаг даргын  
Тамгын газар**

*Хяналт шинжилгээ,  
үнэлгээний тасаг*

**“Бодлогын баримт бичиг”,  
“Холбогдох эрх зүйн акт”-ын  
хэрэгжилтийг тооцох  
аргачилсан зөвлөмж**

№02/03/

**2015 он**

# Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын хяналт шинжилгээ үнэлгээний тасаг



Mass mail

[Batjrgl\\_miee@yahoo.com](mailto:Batjrgl_miee@yahoo.com)

[Sh\\_bldbaatar@yahoo.com](mailto:Sh_bldbaatar@yahoo.com)



Social  
Network



Batjrgl miee



Boldbaatar sharavjamts



ЛАВЛАХ УТАС

7034-3426

**Булган аймгийн Засаг даргын  
Тамгын газар**

*Хяналт шинжилгээ,  
үнэлгээний тасаг*

**“Бодлогын баримт бичиг”,  
“Холбогдох эрх зүйн акт”-ын  
хэрэгжилтийг тооцох  
аргачилсан зөвлөмж**

№02/03/

**2015 он**



